

## **ХКОМ-ЫН БҮРТГЭЛИЙН НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол-Япон Улсын Засгийн газар хоорондын “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл”-д дурдсан ХКОМ-ын Хамтарсан Хороо нь ХКОМ-ын бүртгэлийн нийтлэг үзүүлэлтийг дараах байдлаар тогтоов:

### **А. Тодорхойлолт**

1. "Кредит олгох" гэдэг нь Хамтарсан Хорооны шийдвэрийн дагуу ХКОМ-ын бүртгэлийн менежер төслийн оролцогч тал болон/эсвэл холбогдох Засгийн газрын дансанд ХКОМ-ын кредитийн тодорхой хэмжээний өсөлтийг бүртгэх үйл ажиллагааны журам юм.
2. "Шилжүүлэх" гэдэг нь ХКОМ-ын тодорхой хэмжээний кредитийг өөрийн эзэмшлийн данснаасаа ХКОМ-ын бүртгэлийн системд бий болсон өөр данс руу шилжүүлэхийн тулд тал тус бүрийн данс эзэмшигчийн санаачилсан үйл ажиллагааны журам юм.
3. "Хүлээн авах" гэдэг нь тал тус бүр эсвэл данс эзэмшигч байгууллагын ХКОМ-ын бүртгэлийн системд үүсгэсэн өөрийн эзэмшлийн дансанд ХКОМ-ын тодорхой хэмжээний кредитийг хүлээн авах үйл ажиллагааны журам юм.
4. "Цуцлах" гэдэг нь ХКОМ-ын тодорхой хэмжээний кредитийг цуцлах данс руу шилжүүлснээр ХКОМ-ын кредитийг цаашид шилжүүлэх боломжгүй болгох үйл ажиллагааны журам юм.
5. "Хаах" гэдэг нь ХКОМ-ын кредитийн тодорхой хэмжээг хаалтын данс руу шилжүүлэх үйл ажиллагааны журам бөгөөд ингэснээр ХКОМ-ийн кредитийг олон улсад амласан хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах үйл ажиллагааны нэг хэсэг болгон ашиглаж, цаашид шилжүүлэхгүй.

### **Б. Бүртгэл**

6. Тал тус бүр ХКОМ-ын кредит олгох, эзэмших, шилжүүлэх, хүлээн авах, цуцлах, хаах үйл явцын бүртгэлийг үнэн зөвөөр баталгаажуулахын тулд ХКОМ-ын бүртгэлийн системийг бий болгож, хөтөлнө.

7. Тал тус бүр нь ХКОМ-ыг хэрэгжүүлэх эрх бүхий ХКОМ-ын бүртгэлийн менежерээр өөрийн бүртгэлийг хөтлүүлнэ. ХКОМ-ын бүртгэл өөр байх тохиолдолд хоёр тал сайн дурын үндсэн дээр тус тусын бүртгэлээ нэгдсэн системд хөтөлж болно.
8. ХКОМ-ын бүртгэл нь үнэн зөв, ил тод, үр ашигтай менежментийг хангах зорилгоор ХКОМ-ын кредит олгох, эзэмших, шилжүүлэх, хүлээн авах, цуцлах, хаах зэрэгтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан өгөгдлийн сан хэлбэртэй байна.
9. ХКОМ-ын кредит тус бүрийг тухайн үед нэг ХКОМ-ын бүртгэлийн зөвхөн нэг дансанд хадгална.
10. ХКОМ-ын бүртгэл дараах данстай байна:
  - a) Засгийн газрын данс;
  - b) Хамтарсан Хорооноос зөвшөөрөл олгосон байгууллага бүрд (төсөл хэрэгжүүлэгч тал) нэг данс;
  - c) ХКОМ-ын кредитийг цуцлах тохиолдолд нэг данс;
  - d) ХКОМ-ын кредитийг зорилтдоо (NDC) ашиглах зорилгоор шилжүүлэх "хаалтын" данс
11. ХКОМ-ын бүртгэлийн данс тус бүр дараах элементүүдээс бүрдсэн өвөрмөц дансны дугаартай байна:
  - a) Хэрэгжүүлж буй арга хэмжээний таних дугаар: Дансны дугаарын эхэнд "JCM" бичигдэнэ;
  - b) Улсын таних дугаар: Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO3166) тодорхойлсон хоёр үсэгтэй улсын кодоор тодорхойлогдсон ХКОМ-ын бүртгэлийг хөтлөх улс; болон
  - c) Өвөрмөц дугаар: ХКОМ-ын бүртгэлд данс хөтөлж байгаа улсын тухайн дансанд хамаарах цорын ганц дугаар;

## **В. ХКОМ-ын кредит олгох**

12. ХКОМ-ын төслийн үйл ажиллагаанд ХКОМ-ын кредит олгох тухай Хамтарсан Хорооноос зөвшөөрсний дараа ХКОМ-ын бүртгэлийн менежер Хамтарсан Хорооны шийдвэрийн дагуу төсөлд оролцогч тал болон/эсвэл холбогдох засгийн газрын дансанд тодорхой хэмжээний ХКОМ-ын кредитийг олгоно.
13. ХКОМ-ын кредит тус бүр дараах элементүүдээс бүрдсэн дахин давтагдашгүй серийн дугаартай байна:
- a) Хэрэгжүүлж буй арга хэмжээний таних дугаар: "JCM"
  - b) Хүлээн авагч улсын таних дугаар: Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO3166) тодорхойлсон хоёр үсэгтэй улсын кодоор тодорхойлогдсон ХКОМ-ын төслийг бүртгэсэн хүлээн авагч улс;
  - c) Олгосон улсын таних дугаар: Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO 3166) тодорхойлсон хоёр үсэгтэй улсын кодоор тодорхойлогдсон ХКОМ-ын кредитийг олгосон улс;
  - d) Ялгарлыг бууруулсан эсвэл хассан оныг тодорхойлох: ялгарлын бууралтад хүрсэн жилийг дөрвөн оронтой тоогоор тэмдэглэсэн оныг тэмдэглэнэ;
  - e) Тодорхойлох нэгж: олгосон улсын ХКОМ кредитэд хамаарах цор ганц тоо.

#### **Г. Шилжүүлэх, Хүлээн Авах, Цуцлах, Хаах**

14. Данс эзэмшиж буй байгууллага ХКОМ-ын бүртгэлд бий болсон өөрийн эзэмшлийн данс хооронд ХКОМ-ын кредитийг шилжүүлж авч болно.
15. Тал тус бүр өөрийн эзэмшлийн ХКОМ-ын бүртгэл цуцлах данс руу кредит шилжүүлэх замаар ХКОМ-ын кредитийг цуцалж болно. Данс эзэмшиж буй байгууллага мөн ХКОМ-ын кредитийг цуцлах данс руугаа шилжүүлж болно.
16. Тал тус бүр ХКОМ-ын бүртгэл дэх хаалтын данс руугаа кредит шилжүүлэх замаар ялгарлыг бууруулах зорилтоо биелүүлэхэд ашиглах ХКОМ-ын кредитийг гаргаж болно. Дансны эзэмшигч байгууллага мөн ХКОМ-ын кредитийг хаалтын данс руугаа шилжүүлж болно.

17.Цуцлах эсвэл хаалтын данс руу шилжүүлсэн ХКОМ-ын кредитийг цаашид шилжүүлэх боломжгүй.

#### **Д. Шилжүүлгийн бүртгэл**

18.Тал тус бүр өөрийн эзэмшлийн ХКОМ-ын бүртгэл дэх данс хооронд олгох, шилжүүлэх, хүлээн авах, ХКОМ-ын кредитийг цуцлах, хаах зэрэг шилжүүлгийн хүчинтэй эсэхийг шалгах шилжүүлгийн бүртгэлийг хөтөлнө.

#### **Е. Олон нийтэд нээлттэй байх мэдээлэл**

19.Тал тус бүр нууцлалын бус мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, сонирхсон хүмүүс асууж лавлах, үзэх боломжийг интернэтээр дамжуулан хэрэглэгчтэй харилцах хэсэгт байлгаж мэдээллээр хангана.

20.Дээрх 19 дүгээр зүйлд дурдсан мэдээлэлд ХКОМ-ын бүртгэл дэх данс эзэмшигчийн нэрийн шинэчилсэн мэдээллийг багтаасан байна.

21.Дээрх 19 дүгээр зүйлд дурдсан мэдээлэлд жил бүрийн хуанлийн (Гринвичийн цагаар тодорхойлсон) ХКОМ-ын бүртгэлд хамаарах дараах мэдээлэл агуулагдана.

- a) Жилийн эхэнд ХКОМ-ын бүртгэлд байгаа дансны төрөл (эзэмших, цуцлах, хаах) тус бүрээс авсан ХКОМ-ын кредитийн нийт дүн;
- b) Хамтарсан Хорооноос ХКОМ-ын кредит олгох тухай зөвшөөрлийн үндсэн дээр олгосон ХКОМ-ын кредитийн нийт дүн;
- c) Цуцалсан ХКОМ-ын кредитийн нийт дүн; болон
- d) Хаасан ХКОМ-ын кредитийн нийт дүн.